

БУРИАД ХУРИМ ДАХЬ ХАДАМД МОРДОХ БАСГАНЫ ЁСЛОЛ, ҮЙЛИЙН АНТРОПОЛОГИЙН СУДАЛГАА

Толон^{1,*}

Товч агуулга: Буриад хурим дахь хадамд мордох басганы үдэлтийн ёслол нь басган зайх -эхлэл, басганы их наадам-оргил, басган мордох-төгсгөл гэх гурван хэсэгт алхмаар явагдаж байгаа зан үйлийн цогцолбор болохын хувьд Ван Геннеп (Van Gennep)-ийн нийгмийн шилжилтийн ёслол зан үйлийн онолоор авч үзэж болохоор байна. Басганы салалтын ёслолын зан үйл нь Буриад зоны нийгэм соёлын тусгал илэрхийлэл болохын хувьд өвөрмөц онцлог бүхий утга агуулга, илэрхийлэлтэй байдаг. Энэхүү илтгэлдээ дээрх соёлын онцлогийг судлан шинжлэхийн зэрэгцээ, малжих соёлтой Буриад ба тариалах соёлтой Түжаагийн хадамд мордох басганы үдэлтийн ёслолыг харьцуулан уг ёслолын утга учир болон зан үйлийн онцлог, үүрэг, ач холбогдлыг Франц Баос (Franz Baos) -ийн онолоор тодруулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Буриад хурим, хадамд мордох басганы ёслол

Удиртгал

Буриад бол Монголын эртний аймаг угсаанд багтах ойн иргэдийн нэг юм. Тэдний уугуул нутаг нь Байгал нуур орчим болно. Оросын Октябрийн хувьсгал ба дэлхийн нэгдүгээр дайны явцад Буриадууд Хятад, Орос, Монгол гурван улсад тархаж, улс дамнасан суурьшсан байна. 100 гаруй жилийн турш гурван улсад алслагдсан буриадууд өөр өөр улсын харьяалалд амьдран оршихдоо даяаршил, шинэчлэлийн нөлөөгөөр уламжлалт нийгэм, соёлын онцлог, ялангуяа хуримын зан үйлийн уламжлалаа багагүй алдаж, өөрчлөгдсөөр байна.

Буриад хуримын зан үйлийн судалгаанаас үзвэл, ихэвчлэн Буриад хуримын зан үйлийг дүрсэлсэн, танилцуулгын маягаар бичигдсэн байх бөгөөд нийгэм, соёлын задлан шинжилгээ хийх шаардлагатай байна. Өмнө хийгдсэн буриад хуримын зан үйлийн судалгаа нь ихэвчлэн танилцуулга шинжтэй дүрслэн бичлэг байгааг харгалзвал уг зан үйлийн судалгаанд нийгэм соёлын үүднээс задлан шинжилгээ хийх шаардлага тулгарч байна. Ийм учраас тус сэдвийг сонгож “төр хурим”-ын зан үйлийн уламжлалаа харьцангуй сайн хадгалсан Шинэхээн Буриадын хурим дахь хадамд мордох басганы ёслол, зан үйлийн соёл уламжлал ба нийгмийн үүрэг, ач холбогдлыг антропологийн онол, арга зүйн үүднээс тодруулан бичихийг зорьлоо.

Францын антропологич Ван Геннеп “Шилжилтийн ёслол үйл” гэдэг бүтээлдээ хүмүүс амьдралынхаа явцад хэдэн чухал шат үеийг өнгөрөөдөг. Тухайн үе шат бүр нь хүн нэг наснаас өөр насанд, нэг нийгмийн бүлгээс

нөгөө бүлэгт эсвэл нэг нийгмийн дүрээс өөр дүр рүү шилжих бөгөөд, шилжилтийн үе шат болгонд зохих ёслол зан үйлийг гүйцэтгэдэг. Эдгээр шилжилтийн ёслол зан үйлийг ерөнхийд нь: “Салалтын ёслол, Шилжилтийн ёслол, Нэгдэлтийн нийлэлтийн ёслол” гэх гурван хэсгээр бүрэлдэнэ гэж үздэг. Тэрбээр энэхүү онолынхоо дагуу хуримын ёслол зан үйлийн бүхий л явцад системтэйгээр задлан шинжилгээ хийж хуримын ёслол дахь хүүхэн харьд мордох, хүү эхнэр буулгадаг явцыг гүнзгий судлан, хуримын ёслолоор дамжин шинэ дүрд шилжиж байгааг өгүүлсэн (法阿诺尔德范热内普著 2012). Энэхүү шилжилтийн ёслол, зан үйлийн онолоор шинжилж үзвэл, Буриад хуримын хадамд мордох басганы ёслол зан үйл нь салалтын ёслолын тод илэрхийлэл болж байгаа бөгөөд, уг ёслол басган зайх, басганы их наадам, басган мордох зэрэг нь өөр, өөрийн өвөрмөц утга агуулга, зан үйл, үүрэг зориулалттай хэд хэдэн хэсгийг өөртөө багтааж байна.

1. Басган зайх

Буриадын уламжлалт хуримын заншилд хадамд мордох басганы ойр төрөл нь хуримлахаас нь хэдэн өдрийн өмнө басганаа нөхөдтэй нь хамт гэртээ урьж, хүндлэн зочилж, наадуулан наргиулдаг. Энэхүү хадамд мордох басган хуримын өдөр тултал төрөл саднаараа айлчлан тойрч явдаг энэ зан үйлийг басган зайх гэдэг. Басган зайх нь салалтын ёслол буюу шилжилтийн зан үйлийн эхлэл хэсэг болж хадамд мордох басган төрөл садантайгаа салах ёс гүйцэтгэх утга үүрэгтэй юм.

Басган зайхад ихэнхдээ олонхдоо таваас есөн хүн явна. Гэхдээ хүний тоог сондгой байлгахыг эрхэмлэж, хуримлахдаа шинэ хүргэн нэмбэл нэмэгдэж тэгш тоо болно хэмээн бэлгэшээдэг. Басганы аав ээж нь ойр

¹ МУИС, Антропологи, Археологийн тэнхим, докторант

* Холбоо барих зохиогч: 20D1NUM0085@stud.num.edu.mn

саднаасаа нэг хүнийг явуулж, басганы нөхөд болж явах хүмүүсийг хадаг барьж урина. Гэрлээгүй хөвүүд басгадын бол аав ээжид нь хадаг барьж зөвшөөрөл авна. Ёс журамд нэвтэрхий, үг хэлэнд хурц, дуу хуурт авьяаслаг “өвгөн түрүү” хэмээгч нь гэрлэсэн ахмад томоотой хүн байж болох бөгөөд аливааг зохицуулан зааварлаж, баяр наадмыг үүсгэн явдгаас айл бүхний хайр хүндэтгэлийг хүртдэг. Хөвүүн нөхөр нэг буюу хоёр байж хүрсэн газартаа хамт яваа нөхдийнхөө морь унааг арчлан тохируулж бэлэг сэлт юм хумаа эвлүүлэн авч явна. Басганы хамгийн дотно хоёр буюу гурван эмэгтэй найз нь бараа бололцож бүх талаар харгалзаж явна.

Басганы нөхөд хүрэлцэн ирэхэд, аав ээж буюу ахмад настнууд зөвлөлдөж, суудлыг нь эрэмбэлж суулгана. Хамгийн дээд талд өвгөн түрүү, дараа нь хөвүүн нөхөд, дээд басган нөхөр, хадамд мордох басган, бусад басган нөхөд гэх мэтчлэн хал овог, нас жилээр нь дараалан суулгахдаа өөрийн овгийн хөвүүд басгадаа дээд суудалд суулгана. Хадамд очих басганы танихгүй хүн бол суусан дэс дараагаар нь шууд мэдэж болно. Хэдэн өдрөөр айлчлан явахдаа ахмадын тааруулж суулгасан дэс дарааг нь журамлан сахиж, дураараа сольж болохгүй. Өвгөн түрүүгийн зааврыг сонсон, хадамд мордох басганаа сайхан харгалзаж, ёс горимтой явахыг хичээнэ. Басганы аав, ээж нь айлчлах айл болгонд архи сархад, жимс буурцаг, хадаг алчуур зэрэг бэлгийн зүйлсийг төхөөрч өгнө.

Зайж мордох басган үсээ наймаар гөрж, дээл хувцсаа улирлын байдалд тохируулан гоёж хувцаслана. Хамт явах нөхөд нь ч буриад хувцас заслаараа гоёно. Хамгийн түрүүнд нагацын талдаа айлчилдаг болохоор нагацынх нь ирж, урьж аваачдаг. Дараа нь авгын талын төрөл садандаа айлчилдаг. Айлд ороод мэндлэн золголцож эмхтэй сайн суусны дараа цай аягалж, цагаан идээний таваг тавин амтат сайхан идээ ундааг элбэг өрж, хүндлэн зочилно. Энэ хооронд хөвүүн нөхөр босч, гэрийн эзэн, эзэгтэй хоёрыг суулгаад басганы бэлэг гэж авчирсан бэлэг сэлтээ барина. Цайлуулж байгаа айл нь хонь гаргах буюу бүхэл мах, буриад бууз, шөл зэрэг халуун хоол гаргаж, хүндлэн зочлох бөгөөд байн байн архины дугараа явуулж дуу найр үүсгэнэ. “Жараахайн гол” гэх дуу бол басган зайхдаа заавал дуулдаг дуу болно. Энэ дуунд:

“Харгилан урсдаг Жараахайн гол

Хадаа тойроод урсаа юм.

Хайртай ганцхан басган маань

Хангинатал дуулсаар хадамд очив.

Угалзлан урсдаг Жараахайн гол

Уулаа тойроод урсаа юм,

Уяхан зантай басган маань

Уяртал дуулсаар хадамд очив...” гэж дуулна.

Нөхөд нь энэ мэтээр хадамд очих басганыг уяруулан

догдлуулж, наргин баясуулна.

Дараагийн цайлах айл нь ирж заллага тавихад өвгөн түрүү явахаа мэдэгдэж, дугараагаа шилээн барина¹. Гэрийн эзэн эзэгтэйгээс басгандаа алт мөнгөн засал зэмсгийн зүйл буюу зоос мөнгө гэх мэтчилэн хүнд бэлэг барих бөгөөд хамт явсан нөхдөд нь хадаг алчуур дээр 10, 20 төгрөг нэмж гарыг нь цайлгана. Гэрээс гарахдаа хөвүүн нөхөр нь үүдэнд очиж, малгайгаа сугавчлаад хоёр гараа дэлгэн “... сарын ... өдөр ... басганг маань хадамд хүргэлцэж очооройгт!” гэж урихад гэрийн олон “очно, очно” гэж хариу хэлнэ. Тэгж мордож гараад дараачийн айлд хүрч мөн дээрх мэт зочлон хүндлүүлнэ. Энэ мэтээр хэдэн өдөр төрөл саднаараа айлчлаад хуримын өмнө өдөр гэртээ буцаж ирдэг.

Эрдэмтэн Оюунгоо “Буриадын басган зайх зан үйлийг шинжлэх нь” гэх өгүүлэлд “зайх” гэгч бол “зайлах дутаах буюу далдлах” гэх утгатай, басган зайх зан үйл нь Монгол хуримын ёсон дахь шинэ бэрийг хүргэн заавал хээр талаас барих зан үйлийн өнөөгийн одоох хувилбар мөн. Энэ нь Монгол үндэстний язгуур эртний ураг хуримын дүрэм, ёслол жич түүний урт удаан нарийн ээдрээтэй будлиантай түүхэн замналыг тамгалан үлдээсэн нэгэн ёсны уламжлалт соёлын нандин өв хөрөнгө гэдэг нь ажиглагдаж байна хэмээн үнэлж, Европ жуулчин Гильом Рубрук болон Хятад түшмэл, Сяо Да Хен-ийн тэмдэглэлээр баримт болгон нотолсны хамт энэхүү бэлгэдмэл дууриамал шинж бүхий зан үйлийн түүхэн уг сурвалж нь эртний Монголчуудын дунд байсан булаамал ургийн ёсноос үүсэлтэй болохыг бодит түүхэн явдал, зан үйлийн ул мөр, жич зарим нэрийдэл хэллэгийн үүсэл эрэлттэй ирэлттэй холбон тайлбарласан бөгөөд энэ зан үйлийг гүйцэтгэх учир шалтгааныг эртний Монголчуудын үзэл ухамсар, ёс суртахуун, шүтлэг бишрэл, гоо зүйн таашаал зэрэг талаас сүвэгчлэн, овгийн гадна ураглах ухамсар, баатрыг шүтэх үзэл жич бэлгэдмэл дууриамал зан үйлээс эх үүсэлтэй гэж үзсэн байна. Мөн шинэ бэрийг хээр талаас барих зан үйлээс басган зайх зан үйл болон улирах шилжилтийн явц бол Монгол үндэстний ураг хуримын ёсонд чухал өөрчлөлт хувьсал гарсан явц байж, феодалын эрийн эрх чангарч “Хүргэд талбих ёсон” гээгдээд хүүхнийг хүргэн талд хүргэж холбодог болсноос шинэ бэрийг хүргэн заавал хээр талаас барьдаг ёс орших чухалгүй болж, үүний оронд хүүхэн нь ойр төрөлдөө айлчлах, “Басган зайх зан үйл” болон хувирч тогтжээ хэмээн үзэж, үүний үндсэн үүрэг зориулалт “Торгуудын хүүхэн өрөх ёсон”, “Тайж нарын амсуулын хурим”, “Баргын хүүхэн хэсүүлэх”, “Халхын цай уух”, “Баягуудын цэгээ уух” зэрэг Монголын бусад угсаатны зан үйлтэй мөн адилаартай байгааг дурдан, энэхүү ёс нь

¹ Найрын дугараагаа дуусгахыг дугараа шилээн барина гэдэг.

Манжийн ноёрхлоос зайдуу бөгөөд тариалах соёлын нөлөө багатай ястнуудын дунд ил тодорхой бөгөөд чухал зан үйлийн хувиар явагдаж, Манжийн хүчнээс ойролцоо өвөрлөгч Монголын эл ястны дотор тийм тод товгор өвөрмөц зүйл биш болж хаягдахад хүрчээ гэж дүгнэсэн байна. (Оюунгоо 2009: 6)

2. Басганы их наадам

Шинэхээн буриадуудын нутагшин суурьшиж байгаа газар орны байгалийн нөхцөл ба эрхэлж байгаа малжих үйлдвэрлэлийн бодит байдлаас шалтгаалж, төр хурим нь нийдэмдээ жил бүрийн зургаа, долоо, найман сард төвлөрөн явагддаг зуршилтай. Хадамд мордох басганы их наадмыг их хуримын өмнө орой эцгийнх нь гэрт хийнэ. Басганы төрөл садан, найз нөхөд, хөрш зэргэлдээ хот усных нь оройн нарнаар хуран цугларч ирэхэд гэрийн гадна том тойрог засаж, гол дунд нь түүдэг гал асаагаад баруун талаар нь эрэгтэйчүүд, зүүн талаар нь эмэгтэйчүүд гэхчлэн нас эрэмбийн дараагаар тойрон сууна. Хадамд мордох басган нөхдийнхөө хамт тойргийн дотор талд зүүн талыг барьж дэс дараагаар сууна.

Басганы их наадам нь салалтын ёслолын оргил байж, аав ээжийнх нь хувьд нь авч хэлбэл үдэлтийн ёслол болох бөгөөд хадамд мордох басганы хувьд д авч хэлбэл аав, ээж, төрөл садан, үеийн нөхөд, нутаг усныхаа зон олонтой салахын ёс гүйцэтгэж байгаа явдал болох юм. Басганы их наадам нь “ууц тавих”, “ниргэх”, “бэлхэгийг нуух”, “ёохор хатирах” зэрэг дөрвөн шатаар явагдаж, сургаал захиа хайрлах ёслол үйлийн шинж ба наадан тоглож, дуулан бүжиглэх найр наадмын шинжийг уялдуулсан онцлогтой.

2.1 Ууцын дуу

Басганы их наадам нь хадамд мордох басганд ууц тавьж ууцын дуу дуулахаар эхэлдэг. Ууц хатан хүний хүндэтгэлийн зоогт тооцогддог. Буриадад “Ууц хондлой” гэх хоршоо холбоо үг байх ба “Хормой уужим, Хондлой сайтай” бэрийг үр хүүхэд өнөр өтгөн, үлэмж их хишиг буян хураахын өлзий дэмбэрэлтэйгээр бэлгэшээдэг. Ийм болохоор хадамд мордох басгандаа хонины ууц тавьж байгаа нь энхрий хүүхэндээ хүндэтгэл дэвшүүлж, хүндлэн зочлохын дагуу хамт өнөр өтгөн, үлэмж буянтай байхыг бэлгэдсэн санаа юм. Өвгөн түрүүд хонины төөлэй, хадамд мордох басганд ууц тавьсны дараа, басганы нагац буюу тусгай уригдан ирсэн дуучныг залж, “Ууцын дуу” дуулуулна. Тус дуу нь хадамд мордох басгандаа анхааруулан сануулж, сурган захих агуулгатай сургаалын дуу болно.

“Оргилоо булгийн усанд

Ундлахын тухайд буугаарай,

Орны холыг очив чи,
Олон бүгдийн ёс юм...” гэж басган хүн хадамд очих нь бол амьдралын жам болохыг ойлгуулна.

“Алтан сувд эрдэнийг

Арчин угаан хадгалаарай,

Аав ээж хоёроо

Ачлан туслан хүндлээрэй...” гэж айлын сайн бэр, амраг нөхрийн сайн хань болж явахыг сургана.

“Хөвч газар бартаатай,

Хүлэг морио татаарай,

Хүний газар хэцүүтэй,

Сэрэмжтэй л суугаарай...” гэж амьдралд тохиолдож мэдэх бартааг болгоомжлан сэрэмжилж явахыг сануулна.

“Ардаг ардаг морин чинь

Адуугаа гэж санах,

Айдар баахан бие чинь

Аваа гэж санах,

Эмнэг эмнэг морин чинь

Ижлээ гэж санах,

Эрх баахан бие чинь

Ээжээ гэж санах,

Хадын өндөр модонд

Хан хөхөө донгодно,

Хайрлан тэжээсэн аав чинь

Хүүхнээ гэж санах,

Хөвчийн өндөр модонд

Хөхөө шувуу донгодно,

Хөхүүлэн тэжээсэн ээж чинь

Хүүхнээ гэж санах...” гэж эх эцэг, охин үр харилцан бие биеэн санаж мөрөөдөх сэтгэлийг элэг зүрх шимшрэн уйлж хайлтал дуулна.

“Аав ээжийн сургаалиар

Алдалгүй яваарай,

Ах дүү олныг атаархамаар

Аятайхан нэрийг дуулгаарай...” гэж аав ээжийнхээ сургаалаар алдар нэрээ мандуулж явахыг захимжилна.

“Төлгөн төлгөн хониороо

Төөлэйлүүлээд¹ ч мордов л чи,

Төр засаг хоёроо шүтэхэдч яваарай...” гэж хайрт хүүхнээ хүндэтгэлтэйгээр хадамд мордуулж байгаа ба төр засаг, хууль ёсыг дагаж явах хүний нийгмийн ёс зүйг мэдрүүлнэ.

“Хүрэгч үнээний саамалхан,

Хөгшин ээжийн нэрмэлхэн,

Хүнсний дээж тохуриаг

Хүндэт худ нартаа бария...” гэж хурим найрын дээж дугараа барих ёсоор наадмын олонд хандуулан дуулж төгсгөнө. (Нумаа 2017)

“Ууцын дуу”-г иймэрхүү аяархан намбалаг хөг аясаар сурган захиж, утга ухааруулж дуулахад хадамд мордох басганаас эхлэн аав ээж, цугларсан бүгдээрээ

¹ Төөлэй гэдэг нь хонины толгойг хэлнэ.

цөм тэсгэлгүй уйлж гардаг. “Ууцын дуу” дуулж барвал, өвгөн түрүүгээс төөлэй хөндөж, хадамд мордох басганаас ууц хөндөж, дээжийг нь өргөөд, харилцан “баригти!” гэлцэн тавагнаас хөндөж, ам хүрдэг.

2.2 Ниргэлгийн дуу

Ниргэлгийн дуу нь өмнөх “Ууцын дуу” хүмүүсийн сэтгэлийг аргадах тайвшруулах зорилгоор олуулаа гарч талбайн дунд зогсоод, нурууныхаа араар гараа сүлжин алхаж, дунд зэргийн хөг айзмаар биеэ найгаж дуулдаг дуу болно. Ниргэлгийн дуу нь голдуу Бурханы шашны магтаал буюу аав ээжийн тухай дуунууд байдаг тул дуулах үед хүний сэтгэл аятайхан тайвширч уужирна. “Өндөр уул” гэх ниргэлгийн дуунд

“Өндөр уулын оройгоор
Үүрийн туяа мандана,
Өндөр хөлтэй ширээнд
Зулын туяа мандана.
Навтар уулын оройгоор
Нарны туяа мандана
Навтар хөлтэй ширээнд
Зулын туяа мандана...” гэж дуулна. (Нумаа 2017)

2.3 Бэһэлиг нуух наадам

Буриад хэл ярианд “бэһэлиг” гэгч нь бөгж, бэлзэгийг зааж буй юм. Бэлзэг ба бэлзэгийн цагариг хэлбэр бол эрт цагаас эмэгтэй хүний бэлгэдэл тэмдгээр танигдаж байсан юм. Басганы их наадам дахь бэлзэг нууж эрэх тоглоом нь бэр эрэх ёсон дахь “Эрээд олдохгүй эрдэнэ, сураад олдохгүй сувд” гэх ойлголттой золгодож, охин эрдэнийн бэлгэдэл болж байгаа нь тодорхой. Мөн бэлзэг нь хайр сэтгэлийн холбоосын илэрхийлэл болж, дэлхийн олон үндэстний хуримын ёслолд шинэ хосын харилцан бэлгэдлэг хуримын бэлэг болдог. Ийм болохоор басганы их наадам дахь бэһэлиг нууж, бэһэлигийн дуу дуулах ёс заншил нь буриад монголчуудын охин эрдэнээ хайрлах, ургийн холбоог дээдлэх бэлгэдэл болж, уламжлагдан ирэв. Эрдэмтэн судлаач Г. Гантогтохоос бэлзэг нуух наадам бол их гэрийн наадмын нэгэн эрхэм хэсэг нь бөгөөд хадамд мордох охины гоо сайханы буян хишиг, эдийн буян хишиг, эрдэнийн буян хишгийг даллах бэлгэдлийн агуулгатай юм гэж тэмдэглэжээ (Гантогтох 2007).

Бэһэлиг нуух наадмыг тоглохдоо хүмүүсийг зүүн баруун хоёр тал болгон суулгаад, бэһэлигээ нууж таалгана, тааж чадахгүй бол дуу дуулуулна. Дуу дуулж чадахгүй хүлээлгэж удаан байвал “Баруун нуурын бах /мэлхий/ шиг бархиралдсан болооч, Даага идсэн чоно шиг даргилдсан болооч” гэх буюу “Улаан

хоолойгоо мухудаа бол уураг сүүлээр зүлгээч, Хонгио хоолойгоо мухудаа бол хонины сүүлээр зүлгээч” гэж хорыг нь малтаж шоглон дуулдаг (Нумаа 2017). Бэһэлиг нуух наадм нь өмнөх ниргэлгийн дууны хүмүүсийн сэтгэлийг аргадан тайвшруулсан суурин дээр охин эрдэнэ ургийн холбоогийн бэлгэдэл болсон бэлзэгийг ашиглан, нууж таалгах, дуугаар торгох, хошин дуугаар хорын малтах зэрэг наадам тоглоомын арга хэлбэрээр зон олныг зугаа цэнгэлтэй болгож наадан тоглуулна.

2.4 Ёохор хатир бүжиг

“Монголын Нууц Товчоо”-ны 57-р зүйлд “Монголын жаргалан ину бүжиг хурим бөлгөө, Хотула хаан өргөмжлөөд, Хорхоногийн саглагар модны доор хавирга газрыг халцартал, өвдөг газрыг өлтөртөл дэвхцэн бүжиглэж хуримлаваа” гэж тэмдэглэсэн байдаг. Буриадын Ёохор хатир бүжиг нь эртний тахилгын бүжгээс үүсэлтэй байж. Түүдэг галаа нар зөв тойрч, гар гараа холбон газар дэвсэж байгаад үсрэн харайж дуулан бүжиглэдэг олон нийтийн тойрон бүжиг болно. Эхлэхдээ удаан аажуу байснаа явах тусмаа түргэн хурдан болно. Ёохор хатир бүжиг нь өмнөх бэһэлиг нуух наадмын зугаа цэнгэлийг нэн өндөр түвшинд хүргэж, хүмүүсийг хамгийн ихээр баярлуулан жаргуулдаг. “Арван цагаан хуруугаа атган байж хатирая, аман соохи зуугаагаа хэлэлцэн байж хатирая, яван хатирая, үшээ хатирая...” гэж бүгдээрэн дуулан бүжиглэсээр, үүрийн цолмон гарахад басганы их наадам өндөрлөж төгсдөг (Нумаа 2017).

3. Басган мордох

Хуримын өдрийн эрт басган талд хөвүүн талын хөтлийн ургууд¹ буухад басган талын худ худгуйн түрүү гэх мэт гол хүмүүс угтан авч, золголт хийгээд гэрт урин оруулна. Баруун талаар дээш суулгаж, цай хоол аягалан хүндлэн зочилно. Хөтлийн ургууд авчирсан цай, өрөм, цагаан идээний дээжээ басган талын тавagt нэмэрлэнэ. Энэ нь худ ураг бололцож хоол ундаа нийлүүлж байгаа санаатай. Бараа хураалцах хүмүүс гэж басганы эгч, хүргэн ах гэх мэт залуус барааны тэргэнд хадамд очих басганы эд барааг тээж, тэрэг унааг бэлэн олгоно.

Хадамд очих басган нөхдийн хамт хүндлүүлэн зочлуулж суух бөгөөд басган хүргэж ирсэн төрөл садан, найз нөхөд, танил дасал хүмүүс, басганд зоос мөнгө, засал чимэглэл, торго бүс, алчуур гэх мэт бэлэг барина. Басган мордох цаг болбол “басга булаалдах ёслол” явагдана. Анхандаа хадамд очих басган хэдэн басган нөхөдтэйгээ найман салаа гээгээ

¹ Хүү талаас ирсэн хүүхэн талын ургуудыг хөтлөн дагуулж явх хүмүүс.

холбох буюу бүсээрээ холболдон гар гараа атгалцаж зууралдаад салж өгөхгүй байдаг. Энэ үед хадамд мордох басганы салж ядах сэтгэлийг илтгэсэн: “Хамтдаа байхад хөөр наргиа сайхан, Харьд мордоход хагацаж салах нь хэцүү, Багын үеийн үетэн нөхөд сайхан, Басган мордоход аав ээж хөөрхий” гэж дуулна (Уудам, Үргэн 1987). Басган талаас бэр хөтлөх 2-5 бэр бүрэн гоё хувцаслаж, засал зүүсгэлээ зүүгээд басганыг хөтлөн авч гарахаар оролдож, эвтэй хавтай үгээр ятган сануулна. Яг зууралдаад салж өгөхгүй бол хөвүүн нөхөд нь хүчээр орж салгаж авдаг байв. Басган гэрээсээ мордохдоо мөн 8 салаа гээгтэй, басган дээлээ өмсөж, бэрүүдээр хөтлүүлж, хөвүүн нөхдийн хамт гарна. Басган нөхөд нь дагаж явдаггүй эндээ хоцорно. Ердөө буриадууд басган хүн басга хүргэлцэж очиж болохгүй гэдэг хатуу цээртэй байдаг. Энэ нь басган булаагдахаас сэргийлсэн эртний ёс горим болох нь мэдээж. Басганаа мордохоос өмнө сүү амсуулж, хожмын амьдралын харгуй зам нь ариун цагаан байхыг бэлгэдэнэ. Басганаа мордоод явахад хишиг буян үлэмж дүүрэн байхыг хүсэн зөгнөж, араас нь цагаан идээгээр хишиг даллаж хоцордог. Басган мордоод шууд хадмын газарт хүрдэггүй. Нэлээд явж замаас гараад зайдуухан далд газар зогсож, хүргээчин ургуудын¹ өнгөрөхийг хүлээнэ. Хүргээчин ургууд түр хуримын газар буусны дараа басган сая хүрдэг.

Басган мордох нь салалтын ёслолын төгсгөл болж, үерхэн наадсан охид басгадаасаа салж, өсөж өндийсөн гэр орноосоо холдон, засал зүүтгэл бэлэг бараагаа тээгээд өргөн олон ураг төрлөөрөө хүргүүлэн хадмын газар очдог байна.

Нарийн шинжиж үзвэл хадамд мордох басганы ёслол үйл нь дээрх мэтээр явагдахдаа алхам бүрт тохирсон дуу аялгатай байж. Хөг айзам, хөдлөл үйл, сэтгэлгээ нөлөөллийн хувьд шат шатаар хувиран өөрчлөгдөж байгаа нь харагдана. Америкийн антропологийн эцэг хэмээн алдаршсан Франц Баос “Зүйл бүрийн нийгмийн соёл нь өөр өөрийн түүхэн замнал, онцлог шинж ба хөгжлийн замтай байдаг. Хүн төрөлхтний сэтгэлгээ нь соёлоор шүүгдэн хэвшдэг болохоор өөр өөр соёл ба нийгмийн бүтэцдэх хамт олон нь өөр өөр сэтгэлгээний мэдрэмж ба илэрхийлэлтэй байдаг” гэсэн билээ. (向霞 2020) Малчин соёлтой буриад нь хадамд мордох басганаа нөхөд сэлттэй нь хамт төрхөм төрлөөр нь айлчлан тойруулж, хүндлэн зочилж, наадуулан наргиулж, аав ээж нь басгандаа их наадам эрхэлж, анхааруулан сануулж сурган захих, уяруулан уйлуулж, аргадан тайвшруулах, зугаалуулан цэнгүүлж, баясуулан жаргуулах, зам харгуйг нь ариулж хишиг буян даллах зэргээр үдэн мордуулдаг нь буриадуудын охин үрээ энхрийлэн хайрладаг үзэл сэтгэхүйг илтгэж буйгаар барахгүй, хожим ирээдүйн

амьдралын зол жаргал, сайн сайхныг зөгнөн бэлэгдэж, салалт үдэлтийн сэтгэлгээг илэрхийлж байгаа юм. Тариалах соёлтой бусад үндэстэн угсаатан бас өөр өөрийн арга хэлбэрээр гэрлэх охиноо үдэн мордуулдаг зан үйл бий. Үүнд: БНХАУ-ын Тужаа, Ий, Жуан, Ли Су, Ге Лао, Ханий зэрэг үндэстний бүсгүйчүүдийн уйлан дуулж мордох ба үүн лүүгээ нэлээд төстэй Хятад, Ёо, Чан зэрэг үндэстний дууны танхимд суух зэрэг ёслол үйл нь мөн маш сонирхолтой. Тужаа үндэстнээр жишээлэхэд, Хүүхэн харьд мордохоос өмнө 3 өдөр буюу хэдэн сар эсвэл, хагас жилийн урьд төрхмийн гэрт хүүхний ээж нь голлон эрхэлж, зөвхөн эмэгтэйчүүдийн оролцоотой уйлан дуулж мордох ёслол үйлийг явуулдаг уламжлалтай байв. Энэхүү ёслол үйл нь аав ээжийн ачлал хайрыг уйлан дуулах, эгч дүүгийн ээнэгшсэн сэтгэлийг уйлан дуулах, зууч хүнийг занан хорсож уйлан дуулах, харийн халаас халиран төвөгшөөж уйлан дуулах зэрэг 4 шатаар явагдана (向霞 2020). Хадамд мордох хүүхэн гол дүр болж дээрх агуулгаар уйлан дуулахад, төрхөм ээж ба бусад эмэгтэйчүүд нь мөн аялдан дагаж, ятган аргадах мэтээр хариу барьж хамжин дэмжиж уйлан дуулна. Энэ хүүхэн хэдий их уйлан дуулж байвал, төдий сайн суртал сургаалтай, сэцэн ухаантай, ачлал элбэрэлтэйд тооцогдож, хуримын хоёр талын гэр бүлд хишиг буян хурайлан даллаж байна гэж бэлгэшээдэг. Ийм болохоор Тужаачуудад “Уйлан дуулахгүй бол авах хүнгүй” хэмээх тогтсон хэллэгтэй байж, охидыг багаас нь уйлан дуулж мордох ёслол үйлд дасган сургадаг байв. Үүнээс үзэхэд Буриад ба Тужаагийн хадамд мордох басганы ёслол үйл нь соёлын ялгаагаас болж салалт үдэлтийн сэтгэлгээний илэрхийлэл нь ч ондоо байна.

Ёслол үйл нь дээрх мэт зугаа цэнгэл, сэтгэл илэрхийлэл, сурган хүмүүжил, гоо таашаалын үйлдэлтэйгээр барахгүй хувь хүний хүмүүжил боловсрол, нийгмийн бүлгүүдийн ижилсэл нягтрал, дүрэм журамд чухал үйлдэл үзүүлдэг. Анх хадамд мордох басганы нөхөр болж яваа гэрлээгүй хөвүүд басгадаар жишээлж хэлэхэд басган зайх, басганы их наадам, басган мордох бүхий л ёслол үйлд биечлэн оролцохоор дамжин буриад ардын хадамд мордох басганы нөхөр бараа болох, хүндлэх мэндлэх, зочилж дайлах, хүндлэл даах зэрэг ёс горим ба ардын дуу бүжигт идээшин сурахын улмаас буриад гэх угсаа ястныхаа соёл заншилд ижилсэн нэгдэж, хамтлагийн нягтрал дүрэмчлэлийг ахиулдаг.

¹ Хүүхэн хүргэж буй хүмүүс.

Дүгнэлт

Ван Геннепийн шилжилтийн ёслол үйлийн онолоор шинжилж үзэхэд хадамд мордох басганы ёслол үйл нь буриад хурим дахь салалтын ёслол бөгөөд “Эхлэл, оргил, төгсгөл” бүхий цогц загвартай, тодорхой үүрэг зориулалттай байна. Басган зайх нь салалтын ёслолын эхлэл бөгөөд төрөл садантайгаа салах ёс гүйцэтгэнэ. Басганы их наадам нь салалтын ёслолын оргил бөгөөд 1. Аав, ээжийн хувьд үдэлтийн ёслол болж байхад; 2. Хадамд мордох басганы хувьд аав, ээж, төрөл садан, үеийн нөхөд, нутаг усныхаа зон олонтой салах гэсэн хоёр үндсэн санааг агуулж байна. Басган мордох нь салалтын ёслолын төгсгөл болж, үерхэн наадсан охид басгадаасаа салж, өсөж өндийсөн гэр орноосоо явж байгаа үйл явц болно.

Виктор Турнер “Бэлгэдэл нь зан үйлийн хамгийн үндсэн нэгж байж хүний сэтгэлгээ нийгмийн зан үйлтэй салшгүй холбоотой. Зан үйлийн нийгмийн амьдралд үзүүлэх нөлөө нь зан үйлийн бэлгэдлээр илэрдэг” гэсэн билээ. Буриад басганы их наадмын ууц тавих ёс ба бэлзэг нуух наадам нь хадамд мордох басганы ёслол үйлийн хамгийн жижиг үндсэн нэгжүүдийн нэг боловч шим шүүс сайтай ууцаар басганыхаа өнөр өтгөн үлэмж буянтай байхыг, бэлзэгээр охин эрдэний төлөөлөл болгож, бэлзэг нуух наадмаар ургийн холбоогоо дээдлэх ба буян хишиг даллах бэлгэдэл санааг илэрхийлдэг (Turner & 赵玉燕 2019) ажээ. Ёслол үйл нь зугаа цэнгэл, сэтгэл илэрхийлэл, сурган хүмүүжил, гоо таашаалын үйлдэлтэйгээр барахгүй, хувь хүний хүмүүжил боловсрол, нийгмийн бүлгийн ижилсэл ба нягтрал дүрэмчлэлд чухал үйлдэл үзүүлдэг. Анх хадамд мордох басганы нөхөр болж яваа гэрлээгүй хөвгүүд басгадаар жишээлж хэлэхэд, хэдэн өдрийн туршид ёс журамд нэвтэрхий, үг хэлэнд хурц, дуу хуурт авьяаслаг өвгөн түрүүгийн заавар доор, басган зайх басганы их наадам, басган мордох бүхий л ёслол үйлд биечлэн оролцооор дамжин буриад ардын хадамд мордох басганы нөхөр бараа болох, хүндлэх мэндлэх, зочилж дайлах, хүндийг даах зэрэг ёс горим ба ардын дуу бүжгийг сурч, идээшин боловсрохын улмаас буриад гэх угсаа ястаныхаа соёл заншилд ижилшин нэгдэж, нийгмийн бүлгийн нягтрал нэгдлийг ахиулдаг байна.

Эрдэмтэн Оюунгоо “Буриадын басган зайх зан үйл нь Монгол хуримын ёсон дахь шинэ бэрийг хүргэн заавал хээр талаас барих зан үйлийн одоох хувилбар мөн. Энэ нь Монгол үндэстний язгуур эртний ураг хуримын дүрэм, ёслол жич түүний урт удаан нарийн будлиантай түүхэн замналыг тамгалан үлдээсэн нэгэн ёсны уламжлалт соёлын нандин өв хөрөнгө мөн” хэмээн үнэлсэн юм. Буриадын хадамд мордох басганы ёслол үйлд басган зайхаас гадна, басга булаалдах,

басган нөхөрт суудал тааруулахдаа өөрийн овгийн хүнийг дээд суудалд тохируулах, басган хүн басга хүргэж болохгүй зэрэг ёсон буюу цээрлэлд эртний булаамал ургийн ул мөр мөн хадгалагдсаар байна. Энэ нь буриад хуримын түүхэн хөгжлийн жам ёсыг судлахад чухал ач холбогдолтой.

Малжих соёлтой Буриад ба тариалах соёлтой Түжаагийн хадамд мордох басганы салалтын ёслолыг харьцуулж үзэхэд Буриад нь басганаа хүндлэн зочилж, наадуулан наргиулж мордуулдаг байхад, Тужаа нь охиноо уйлуулан дуулуулж мордуулдаг байна. Мөн Буриад, Тужаагийн басганы ёслол үйлд дуу бүжиг чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд, дуу бүжгээр дамжуулан сэтгэл хөдлөлийн өөр өөр өнгө аясаа илэрхийлж байгаа нь Франц Баос (Franz Baos) -ийн онолын илэрхийлэл болж байна.

Abstract

ANTHROPOLOGICAL STUDY OF WOMEN'S CEREMONIES AND FUNCTIONS IN BURIAD WEDDINGS

by Tao Long

In Buryat wedding, the ceremony of basgan's (bride's) leaving to in-law is a ritual complex that takes place in three steps: the beginning – visiting relatives, the peak – basgan's great celebration and the end – basgan's leaving. In this case, theory of social transition ceremony from Van Gennep will be considered and applied. As the reflection of the Buryat social culture, the ceremony of basgan's leaving has a unique meaning and expressive behavior. In this report, in addition to analyzing the process mentioned above, I clarified the meaning of this ceremony and the its features, roles, and importance by comparing the nomadic cultural Buryat basgan's leaving ceremony and farming cultural Tujaa bride's leaving ceremony, according to the theory of Franz Baos.

Keywords: Buryat wedding, ritual of giving away the bride

Ном зүй

Алтанцэцэг, С., Толон. (2019). Буриад хэл соёлын судлал. Хайлаар: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.

Бадамхатан, С., Цэрэнханд, Г. (2013). Монгол улсын угсаатны зүй. III боть. УБ.,

Баясах, Ж. (2002). Монгол улсын гуравдахь хөрш хийгээд түншлэлийн асуудалд. Монгол улсын үндэсний аюулгүй байдал ба гурав дахь түнш орнууд:

Өнөө, Ирээдүй. УБ.,

Гантогтох, Г. (2005). Дашбалбар, Дашибалбарайхин. УБ.,

Гантогтох, Г. (2007). Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал. УБ.,

Нумаа, А. (2017). Буриад ардын дууны түүвэр. Хайлаар: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. Оюунгоо. (2009). Буриадын Басган Зайх зан үйлийг шинжлэх нь. Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 21-25.

Толон, Энхцэцэг, Баярмаа. (2019). Шинэхээн Буриад зан үйл. Улаанхад: Өвөр Монголын Шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо.

Ундрал, О. (2017). “Барга хуримын ёслол ба нийгмийн байр суурийн өөрчлөлт” Магистрын зэрэг горилсон бүтээл.

Хорлоо, П. (2003). Монгол туургатны хуримлах ёсны уламжлал ба зан үйл. Бээжин: Үндэсний хэвлэлийн хороо.

Цацрал. (2020). “Орчин үеийн Цахар хуримын уламжлал ба хувьсал” Магистрын зэрэг горилсон

бүтээл. Уудам, Үргэн, Ц. (1987). Монгол хурим. Хайлаар: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.

尹诗媛. (2022). “川东汉族婚俗“坐歌堂”仪式的传承与保护研究——以四川省广安市为例” 硕士学位论文. 李佼佼. (2016). “河湟汉族婚礼中的女性民俗研究以乐都区碾伯镇为个案” 硕士学位论文.

常世伟. (2013). “当代锡尼河布里亚特蒙古族婚礼中的礼物流动” 硕士学位论文.

向霞. (2020). 土家族哭嫁习俗中女性情感表达与主体意识建构的 人类学研究.

桂丽. (2012). “布里亚特婚礼仪式及社会角色的转换研究——以锡尼可镇为例” 硕士学位论文 法阿诺尔德范热内普著, . (2012). 过渡礼仪. 北京: 商务印书馆.

Turner, V., 赵玉燕. (2019). 象征之林. 北京: 商务印书馆.

